

ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ ДЭХ
ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Л. Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (ScD), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: ертөнц, их гүрэн, сэтгүүл зүй, олон улсын мэдээлэл, геополитик, номлол, газар зүй, геостратеги, соёл иргэншил.

Монгол оронд төлөвшиж байгаа ардчилсан тогтолцооны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон улсын амьдралыг тусгах хэмжээ, хүрээ далайц эрс өссөн билээ. Бас олон улсын үйл явдлыг мэдээлэхдээ хоёр систем, үл эвлэрэх зөрчлийн номлолыг хэт баримтлан үзэл сурталждаг байдлаас ангижирч, түүний оронд геополитикийн үүднээс хандах чиглэл давамгайлах болсон юм. Өөрөөр хэлбэл дэлхий дахинд болж байгаа үйл явдлыг тусгахдаа эдийн засаг, газар зүйн байршил, аюулгүй байдлын талаас нь түлхүү анхаарч, өөрийн оронд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг бодолцох болсон гэсэн үг юм.

Дэлхийн их гүрнүүд нөлөөнийхөө хүрээг хуваах тэмцэл ид өрнөж, геополитикийн уламжлалт хэмжүүрүүд хэлбэржин тогтож эхэлсэн XIX зууны сүүлч үеэс олон улсын харилцаанд орон зай, газар нутгийн хүчин зүйлийг онцлон харгалзах болсон байна. Орчин

үед орон зай, хүн хоёр харилцан шүтэлцээтэй байх тухай геополитикийн үндсэн ойлголт дээр шинжлэх ухаан техникийн хувьсгалын үр дүн болсон зэвсэг техник, холбоо мэдээллийн хөгжил, шинэ технологийг зайлшгүй харгалзах болжээ.

Олон улсын харилцаанд гарч байгаа шинэ хандлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хамгийн түрүүнд мэдэрч, үйл явдлын өрнөлтийг үндэсний эрх ашгийн үүднээс харж үнэлэлт дүгнэлт хийж байх шаардлагатай юм. Монголын сэтгүүл зүй энэ талаар багагүй уламжлал, туршлага хуримтлуулсан байна.

Монголын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд бараг үүссэн цагаасаа эхлэн олон улсын мэдээллийг нийтлэл, нэвтрүүлэгтээ ашиглаж ирсэн гэж үзэх үндэстэй. Манай ууган тогтмол хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг» гэхэд л дэлхийн олон улсын тухай мэдээллээс өөрийн орны хувь заяа, хөгжил дэвшилд хамаатай, үлгэр загвар, санаа сэрэмж авахуйц хэсгийг ямар их ухаалгаар сонгож, өөрөөр хэлбэл геополитикийн ач холбогдлыг нь харгалзан мэдээлж байсныг харж болно.

«Шинэ толь хэмээх бичиг» тэр үедээ өндөр хөгжилтэйд тооцогдож байсан Англи, Франц, Герман, Итали, Япон, түүнчлэн хөрш зэргэлдээх Орос, Хятад зэрэг орны улс төр, нийгмийн байдал, аж ахуй, соёлын хөгжлийн тухай тодорхой бичиж байжээ. Гэхдээ Өрнө, Дорнын улс орнуудын тухай бичихэд хөгжил дэвшлийнх нь туршлага, үлгэр жишээг онцлон мэдээлж байсан бол урд, хойт хөршийн тухай нийтлэлдээ тэдгээрийн баримталж байгаа улс төрийн бодлого, үйл ажиллагаа бидэнд ямар хамаатай вэ? гэдгийг илүү анхаарч байсныг онцлон тэмдэглэвэл зохино.

«Шинэ толь хэмээх бичиг»-т Япон улсын тухай бичсэн зүйлд «...эдүгээ тавь жаран жилийн өмнө Европын улс лугаа байлдаан хийж, нэгтэйгүүр оюун хурц олон залуусыг олон улсад зарж, зүйл бүрийн эрдмийг сургаад, бас нөгөөтэйгүүр гадаад улсаас эрдэмтнийг залан авчирч, олон зүйлийн их бага сургууль байгуулж тэдгээр улсуудын тоонд багтжээ» гэсэн бол Болгар улсын тухай бичихдээ «Болгар улсын хүчирхэг болсон нь гагцхүү язгуур угсаа бодохгүй, ард албатыг нэгэн адил үзэж, олон нийтээр зөвлөн хэрэг шийддэгээс энэ мэт сайн болжээ. Улсын сайдын тушаалд эрдэмтэй шударга бол хэн боловч оржээ. Энэ улсын сайд ер ихэмсэглэх заншил огт үгүй. Ард албат байтугай сайн түшмэд ба эзэн хаан ч ажил үйлдвэрт хичээх тул зүв зүгээр

сул сууж жаргал эрхлэгчид нэгээхэн ч үгүй. Дорд ба дунд сургууль бол өөрийн нутагт сургана. Дээд сургуулийг их Орос улсын газар явуулж сургана. Болгар улсын хуулиар сургуулийн нас гүйцсэн залуус эр, эм хэн ч ялгаагүй эрх биш сургууль хийх ёстой тул хүн цөм эрдэмтэй болой» гэхчилэн бичиж байжээ. Дээрх өгүүллүүд нь Азид өндөр хөгжсөн Япон улс хийгээд Монголтой адил харийн дарлалд олон

зуун жил талхиулсан Болгар улс эх орноо яаж цэцэглүүлж байгаагаас үлгэр авахуулах зорилготой нь илт байв. Түүнчлэн том гүрнүүдийн улс төрийн болон худалдаа наймааны бодлогоос улс орондоо учирч болох уршигт үр дагавраас сэрэмжлүүлсэн мэдээлэл

ч гаргаж байжээ. Тухайлбал: Англи улсын худалдааны нэг компани Монголоор дамжуулан хар тамхи наймаалах гэсэн хүсэлтийг Монголын засгийн газар зөвшөөрсөн тухай мэдээг сониныхон түгшүүртэйгээр нийтэлж, улмаар хар тамхины хор хөнөөлийг сэтгэлд үлдэцтэй үгээр сэнхрүүлэн бичсэн байдаг. Тус сонины ажилтнууд олон улсын сэдвээр бичсэн нийтлэлдээ улс төрийн бодлогын зэрэгцээ гэгээрүүлэх чиглэлийг хамт барьж ажилладаг байсан онцлог ажиглагддаг. Дэлхийн хүн ардын тоо толгой, амьдралын хэв маяг, арьс өнгө, насжилтын тухай бичсэн зүйлүүдээс үүнийг мэдэрч болно.

«

***«Шинэ толь хэмээх бичиг» тэр
үедээ өндөр хөгжилтэйд
тооцогдож байсан Англи,
Франц, Герман, Итали, Япон,
түүнчлэн хөрш зэргэлдээх Орос,
Хятад зэрэг орны улс төр,
нийгмийн байдал, аж ахуй,
соёлын хөгжлийн тухай
тодорхой бичиж байжээ.***

»

«Шинэ толь хэмээх бичиг»-ийг заримдаа Монголын сэтгүүл зүйн "Нууц товчоо" гэж нэрлэмээр санагддаг. Судалгааны ширгэшгүй ундарга болсон энэ сонин Орос, Хятад улсаас Монголын талаар явуулж байсан гадаад бодлогыг гайхамшигтай уран арга хэлбэрээр ёгтлон бичиж байсны жишээ нь «Их ноён Хуучин, мэргэн багш Ёст, орос Магад, хятад Ёслол нар ажиггүйн оронд зөвлөн тэмцсэн дөрвөн замын уулзвар нь»¹ хэмээх нийтлэл юм. Энэ нийтлэл хэдийгээр барих баримт нотолгоогүй, уран сайхны зохиомжийн маягтай боловч Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааны мөн чанар, зөрчилтэй, тулгамдсан асуудлыг оновчтой илэрхийлж чадсанаараа онцлогтой болсон билээ.

Гэвч энэ нийтлэлийн далд ёгт санааг тэр үеийн ихэс дээдэс мэдэж ихээхэн сэжиглэсэн нь сонины гаралтыг зогсоох нэг шалтгаан болсон билээ.

Уг нийтлэлийн агуулгыг хэвлэлийн түүх судлагч, доктор Г.Дэлэг тодорхойлж бичихдээ «Уг өгүүлэл хэдийгээр бүрэн нийтлэгдээгүй боловч Монгол улсын үндэсний тусгаар тогтнол, бие дааж хөгжих асуудал хийгээд дотоод байдлаа төвхнүүлэн сайжруулахыг дээрх этгээдийн хэн алинд нь ч итгэж хийх ба хангахад бэрхтэй гэсэн ойлголтыг уншигчиддаа төрүүлж, эдгээр этгээдэд аль нэг хэмжээгээр жигших, итгэл алдаж, сэжиглэх явдлыг төрүүлэхээр бичигджээ»² гэсэн байдаг.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийнхэн олон улсын сэдвээр бичсэн нийтлэл бүхнээ улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах тэмцэлтэй нягт холбон тавьдаг байв. Сонины 1913 оны

дугааруудад Монголын аливаа ёстой үнэнч хүслийг хангахгүйгээр үл барам өөртөө эзэрхэх эрхийг дуустал арилгаж өөрийн нэг муж болгосугай гэсэн Хятадын засгийн газрын бодлогыг Богд хаан мэдээд Орос улсаас тусламж гуйж, элч зарсаныг Оросын засгийн газар хүлээн авсан тухай, Хятадын засгийн газрын хэрэг зөвлөн шийтгэх хуралдаанд Гадаад Монголын төлөөлөгч хэмээх 27 хүнийг хуурамчаар суулгаж, Монгол, Төвд хоёр тусгаар тогтносон нь цөөн тооны урвагчдын хийсэн ажил мөн бөгөөд олонх ард нь Хятадыг дагасан хэвээр байгаа тухай хэлэлцсэнийг Харбины «Юван Дун бао» сонин бичсэн тухай зэрэг олон улсын сэдэвтэй тайлбар өгүүллүүд гарч байжээ. Бас «Оросын доод хуралд Монголын хэргийг шүүмжилсэн нь», «Монгол газрыг колони болгосугай гэсэн нь» зэрэг өгүүлэл нийтэлсэн нь их гүрнүүдээс монголын талаар баримталж байсан улс төрийн бодлогыг илчилсэн даацтай бичлэг болсон юм.

Манай анхны хувьсгалт нууц хэвлэл – «Монголын үнэн» ч олон улсын амьдрал, түүний дотор тухайн үед Монгол орны гадаад байдалд ихээхэн нөлөөтэй байсан Орос, Хятад, Япон гүрнүүдийн тухай мэдээллийг байн байн нийтэлж байжээ. Тус сонин «Монгол улсын ардын эрхт засаг тогтсоны тус»³ гэсэн гарчигтай өгүүлэлд «Олноо өргөгдсөн есдүгээр оны сүүлчээр гадаад Монголын автономит эрх мөхөөгдөхөд Монгол улс хүнд дарамтад дарагдан, буцалтгүй сөнөхөд хүрэв гэж санагдаж билээ. Учир юунд гэвэл тэр үед Монголын гадаад дотоод нөхцөлд Монгол улсын тусгаар тогтнолын үйлсэд ашиг тус болохоор зүйл үнэндээ байсангүй. Гадаад

байдал гэвэл Орос улс өөр хоорондоо тэмцэлдэж, Колчак, Симёнов нар Сибирийг эзэлж, Япончууд Хятадын хоёр мужийг эзэлж, Хятадыг Монгол өөд түлхэж, улмаар Оростой мөргөлдүүлэхийг чармайж байв. Бас энэ үед Монгол улс өөртөө эзэрхэх эрхийг өөрсдийн дотоодын хүчээр олж чадах итгэмжгүй байв. Автономит эрхийг устгах хэрэгт гар бие оролцсон Монголын эрх баригчид улсын эрх барьж засах чадалгүйгээ нэгэнт харуулсан байлаа» гэж бичсэн байдаг. Хамрах хүрээ, тусгасан асуудлаараа энэ нь олон улсын байдлын тухай тайлбар өгүүллийн шинжтэй зүйл байв. Иймэрхүү өгүүлэл сонинд үе үе гарч байсны жишээнд «Хятадын сайд нар Монголын засаг төрд хөтөлбөрлөх хэрэг үйлсийг бүтээж, олон ардын аж төрөх алив байдлыг сайжруулна хэмээдэг. нь мэхлэн байж идэх гэсэн санаа мөн нь тодорхой мэдэгдэнэ. Юун гэвэл цэргийн хүчээр газар орныг эзлэн авсан шунахай эзэрхэг үзэлтэн нь, эзлэгдсэн улсын тусын тулд юм хийхийг нэгээхэн ч үл хичээх бөгөөд эзэлсэн орон газрын аливаа хэрэглэгдэхүүн бүхнийг цөлбөн ашиглах хийгээд ард олныг мөлжин идэж, аливаа муу авир үзүүлэн дарлан зовоохоор үл барам, үзэл суртал, эрдмийг нь таслан, үндэс язгуурыг нь доройтуулан залгихын тулд өөрсдийн суртлыг нээхийг эрхэмлэн оролдох нь Монгол газраа илэрхий үзэгдэж амуй» хэмээн бичсэнийг дурдаж болох юм.

«Монголын үнэн» сонин олон улсын амьдралыг шог хошин болон ухуулгын аястай зураасан зургаар илтгэн харуулж байсан нь нэн сонин юм. Тухайлбал тус сонины дөрөвдүгээрт хөсөр унасан хүнийг ноход

боорлож байгаа, түүнийг хоёр хүн сугадан босгож байгаа, улмаар боорлож байсан ноход зугатан зайлж байгааг гурван өөр зургаар харуулжээ. Хөсөр унасан хүн нь Монгол улс, боорлогч нь Орос, Хятадын түрэмгий цэрэг, хүнийг түшин босгож, боорлогчдыг үлдэн хөөгч нь Орос, Монголын ах дүү хоёр нам ажээ. Мөн Япончуудаас Солонгост хийсэн дайн, Японы гар хөл болсон атаман Семёнов, барон Унгерн нар болон Зөвлөлт, Монголын цэргүүд цагаантны хүчийг бут ниргэж байгаа зэргийг харуулсан цуврал зургууд сонины дараагийн дугаарт нийтлэгдэж байжээ.

Хувьсгал ялсны дараахан буюу 1922 оны 6 дугаар сарын 22-ноос эхлэн нэг жилийн дотор нийт 92 дугаар гаргасан «Хураангуй сэтгүүл» хэмээх сонин манай олон улсын сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Уг сонин тухайн цаг үеийнхээ олон улсын амьдралын онцлог үйл явдлуудыг үндсэнд нь тоймлон харуулж чаддаг байв. Сонины талбайн гуравны хоёроос багагүйг олон улсын мэдээлэлд тавьж өгсөн байдаг. Тухайлбал тус сонины гуравдугаарын хоёр, долдугаарын нэг, наймдугаарын хоёр материалаас бусад нь бүхэлдээ олон улсын амьдралд зориулагдсан байна.

«Хураангуй сэтгүүл» сонин «Тус газар орны сонин» гэсэн булангийн дор дугаар бүрт өөрийн орны тухай 2-3 мэдээ тавьдаг хэрнээ «Гадаадын сонин» гэсэн булангийн олон улсын мэдээгээр ихэнх талбайгаа дүүргэдэг байв. Тус сонины есдүгээрийн эхэнд тавьсан «Ардын засгийн нэгэн жилийн баярын тухай» гэсэн мэдээнээс бусад бүх материал олон улсын сэдэвтэй

байна. Энэ дугаарт «Японы сонин», «Япон улсын чухал сонин», «Оросын оргодол Миркуловын чимээ», «Дундад улсын сонин», «Гадаад шашин суртлуудын мэдэлтэн нар тэмцэлдээнтэй», «Оросын цагаан хулгайн чимээ», «Түрэг, Грек хоёр улсын сонин» гэх мэт мэдээ, тайлбар нийтлэгджээ.

Манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд олон улсын мэдээлэл, тайлбар, тойм нийтлэх арвин туршлага хуримтлагдсан хэдий ч социализмын үед хоёр системийн үл эвлэрэх тэмцэл, хөрөнгөтний үзэл суртлын гаж нөлөө гэх мэт асуудалд түлхүү анхаарч, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс, хөгжил дэвшлийн асуудлыг орхигдуулж байсныг үгүйсгэх аргагүй юм.

Коммунист систем задарч, хүйтэн дайны үе дууссанаар Монголын болон дэлхий дахины олон улсын сэтгүүл зүйн тусгах объект, сэдэв, хамрах хүрээ ихээхэн өөрчлөгдсөн билээ. Дэлхий ертөнцийн амьдралд гарч байгаа өөрчлөлтүүд, тухайлбал хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс болох ардчилал, хүний эрх, төрт ёс, олон ургальч үзэл, зах зээлийн нийгмийг хааяагүй хүлээн зөвшөөрөх болов. Энэ нь олон улсын сэтгүүл зүй үзэл суртлын хэрэгсэл биш, харин хүн ардынхаа нийтлэг хэрэгцээг илэрхийлэгч байх бололцоог бий болгож байна. Бүс нутгийн интеграц эрчимжиж, эдийн засгийн хөгжилд тулгуурласан хүчний төвүүд бий болов. Хойт Америк, Баруун Европ, Японы зэрэгцээ Хятад, Зүүн Өмнөд Ази, Латин Америкт хүчирхэг бүс төлөвшиж эхэллээ. Хүн төрөлхтөн урьд байгаагүй их уялдаа холбоотой гариг ертөнцөд аж төрөх болсон нь гадаад мэдээллийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна. Үүнтэй

уялдан улс төрийн амьдралыг голчлон тусгадаг байсан олон улсын сэтгүүл зүй дэлхийн эдийн засгийн хөгжил, харилцаа, хамтын ажиллагаанд аажмаар шилжиж байна. Ялангуяа геополитикийн судалгааны үндсэн асуудлын нэг болох эдийн засгийн хүчин зүйлийг харгалзан үзэх явдал гадаад мэдээллийн чухал зорилт болж байна. Ирэх зуунд үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөнд эдийн засгийн асуудал тэргүүлэх болно. Үүнийг шийдвэрлэхэд улс төр, цэргийн хүчийг ашиглахыг ч үгүйсгэх аргагүй.

Дэлхийн дайны аюул багассан боловч бүс нутгийн мөргөлдөөнт цэг олшров. Ойрх дорнод, Зүүн-Өмнөд Ази, Солонгосын хойг зэрэг тэсрэх аюултай бүс нутгийн тоо нэмэгдэж, Олон улсын алан хядагчдын заналхийлэл, Ирак, Умард Солонгосын асуудал хурцадсан зэрэг нь олон улсын сэтгүүл зүйн анхааралд зүй ёсоор өртөж байна. Дорнод Европын орнууд Европын их гэр бүлдээ нэгдэж, өрнөдийн үнэт зүйлсийг баримжаалах болов. ОХУ, БНХАУ-ын харилцаа идэвхжиж, дэлхийн хүчний шинэ туйл төлөвших хандлагатай боллоо. Энэ бүхний нөлөөгөөр манай олон улсын сэтгүүл зүйн тусгаж ирсэн дархан сэдэв – Дорнод Европын социалист орнууд ба их анд Орос, түүний дайсан Хятад гэсэн баримжаа аль хэдийнээ алдагдаж, биднийг олон жил бичиж ирсэн сэдвээ эргэн харахад хүргэсэн билээ.

Орчин үед маргаантай асуудлыг шийдвэрлэх гол арга нь дайн байхаа нэгэнт больжээ. Зэвсгийн хөнөөх чадвар ихсэж, сэргөлдөгч талуудын хохирол нэмэгдсэн нь цэрэг зэвсгийн хүч хэрэглэхээс татгалзахад нөлөөлж байна. Харин өнөөгийн хүчирхэг улсууд

эдийн засаг, санхүү, технологи, мэдээлэл харилцааны давуу талаа ашиглан дэлхий дахинд нөлөөгөө тогтоохыг илүү хялбар, хохирол багатай, үр ашигтай арга хэмээн үзэх болжээ.

Энэ хандлагыг мэдээллийн даяаршил тэргүүлж байна. Хүйтэн дайны дараа олон улсын харилцааны шинэ систем төлөвшиж амжаагүй байхад АНУ, түүний нөлөөний хүрээнд багтдаг орнуудын дипломат бодлого дэлхийд ноёрхсонтой холбоотойгоор олон улсын сэтгүүл зүйд барууны мэдээлэл гол чиг баримжаа, даган дуурайх жишээ болж байв. Өөрөөр хэлбэл олон улсын маргаантай асуудал, үйл явдлыг тусгахад Америкийн үзэмжээр хандах явдал илт өссөн юм.

Өнөөдөр дэлхийн улсуудын харилцаа хамтын ажиллагааны зарчимд үндэслэх болсон нь олон улсын сэтгүүл зүйн шинэ хандлагыг тодорхойлж байна. Улс төрийн шийдвэрийг удаашруулдаг талтай ч аливаа асуудлыг төгс, эргэлт буцалтгүй шийдвэрлэх боломжоор илүү байдаг харилцан ойлголцох зарчмаар бат бэх энх тайван тогтоохыг дэлхий нийтээрээ эрмэлзэх болжээ. Иймээс бие биесээ харлуулан дайралцахын эсрэг мэдээллийн дипломат бодлого баримтлах чиглэл олон улсын сэтгүүл зүйд нэвтэрч эхлэв. Өнөөгийн сэтгүүлчид олон улсын амьдралд дипломатч, төрийн зүтгэлтний хэм-

жээнд оролцож, нөлөөлөх боломжтой боллоо.

Энэ нь нэг талаас сэтгүүл зүйн мэдээлэл нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг давуу талтай, нөгөө талаас болзошгүй байдлыг урьдчилан тайлбарлахыг зорьдог олон улсын сэтгүүл зүйн онцлогтой уялдан гарч ирсэн юм. Энэхүү давуу тал, онцлогоороо олон улсын хооронд хэл амаа ололцох, итгэлцэл бий болгох сэтгэл зүйн таатай

нөхцлийг бэлтгэж өгдөг сэтгүүлчдийн үүргийг шийдвэр гаргах эрх мэдэлтнүүдийн зиндаанд тавихад хүргэсэн байна.

Манай олон улсын сэтгүүл зүйн үндсэн зорилт нь улс орныхоо гадаад бодлогын хэрэгжилтэд туслан, дэмжих явдал мөн. Сэтгүүл зүйг үзэл суртлын

«

*Олон улсын сэтгүүл зүй ийнхүү
улс орныхоо гадаад бодлогын чиг
шугамыг тууштай
илэрхийлэхийн тулд үндэснийхээ
эрх ашгийг дээдлэн хамгаалах,
хүн төрөлхтний нийтлэг үнэт
зүйлийг түгээн дэлгэрүүлэхэд гол
анхаарлаа хандуулах
шаардлагатай болж байгаа юм.*

»

төдийгүй, дипломатын хэрэгслийн үүрэгтэй гэж үзэх хандлага ч бий болжээ. Өнөөдөр манай оронд олон улсын сэтгүүл зүй улс орноо гадаадад таниулах, гадаадын мэдээллээр иргэдээ хангах үндсэн хоёр чиглэлээр хөгжиж байна. Олон улсын сэтгүүл зүй ийнхүү улс орныхоо гадаад бодлогын чиг шугамыг тууштай илэрхийлэхийн тулд үндэснийхээ эрх ашгийг дээдлэн хамгаалах, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэхэд гол анхаарлаа хандуулах шаардлагатай болж байгаа юм.

Өнөөдөр манай олон улсын сэтгүүл зүй юуны өмнө гадаад орнуудын тухай бодит мэдээллээр

хэрэглэгчдийг хангах үүрэг гүйцэтгэж байна. Ингэхдээ олон үзэл бодлыг тусгаж, баримтыг тал бүрээс нь харуулж, уншигч, үзэгчдэд өөрийн дүгнэлт хийх боломж олгохуйцаар мэдээлэх аргад тулгуурлаж байна. Ингэснээр олон нийтийг нэг үзэл бодолд туйлшруулах бус, харин дэлхий ертөнцийг бодитой харахад нь туслах болно.

Олон улсын харилцааны ээдрээтэй асуудал ихээхэн зүтгэл чармайлт, цаг хугацаа шаардаж шийдвэрлэгддэг учраас түүнийг мэдээлэх үйл явц нь үйл явдлын эхлэл, өрнөл, туйл, тайлал гэж болохуйц цогцолбор мэдээллийн шинжтэй, олон эх сурвалж ашигласан байж гэмээнэ илүү бодитой болдог ажээ. Олон улсын мэдээллийн бас нэг үүрэг нь өөрийн оронд ашигтай мэдээлэл түгээх явдал юм. Гаднаас авах мэдээллийн хувьд манай улс оролцсон буюу эрх ашиг нь илэрхийлэгдсэн үйл явдал, газар нутгийн онцгой хамааралтай Орос, Хятад зэрэг орны мэдээ чухал суурь эзэлдэг. Харин гадагш гаргах мэдээнд улс орныхоо олон улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэхэд тус болохуйц байдлыг үндсэн шалгуур болгодог байна. Түүнчлэн бүс нутаг, улс гүрнүүдийн ашиг сонирхлыг харгалзан үзэж сонголт хийдэг. Сүүлийн үед манай сэтгүүлчид дэлхий дахины аливаа үйл явдалд өөрсдөө оролцож, байр сууриа илэрхийлэн амьд сурвалжлага хийх болсон нь гадаадын эх сурвалжаас авсан мэдээллээс илүү үнэмшилтэй, үр нөлөөтэй болж байгааг тэмдэглүүштэй.

Сүүлийн үед манай сэтгүүлчид олон улсын мэдээллийг бэлтгэхдээ идэвхгүй дамжуулах аргаас зайлсхийж,

хэрэг явдал яаж өрнөхийг урьдчилан харах, нөлөөлөхийг эрмэлздэг болсон нь сайшаалтай юм. Хөндий хоосон албархах бус, асуудлын мөн чанарыг нээж, гэгээрүүлэх чиглэлийг авч явах, ингэхийн тулд бичлэгийн шинжлэлт зүйлүүдийг хэрэглэх хэмжээ өсч байна. Үүнд сэтгүүлчийн бүтээлч хандлага, өндөр мэдрэмж, гүнзгий мэдлэг чухал юм.



нөөгийн өөрчлөгдөн хувьсаж байгаа дэлхий ертөнцийн хүмүүст орчин нөхцлөө зөв мэдэрч, оновчтой шийдвэр гаргаж, цаг, хөдөлмөр, хөрөнгөө хэмнэж, арвижуулахад олон улсын мэдээллийн үүрэг улам өссөөр байна. Тэрхүү мэдээлэл нь дэлхий дахины худалдаа, соёл хийгээд улс орнуудын үзэл суртал, байршил, чиг хандлага, харилцан үйлчлэлийн цогц байдлыг багтаадаг геостратегийн баримжаатай байх явдал чухал юм.

Манай оронд хөгжиж байгаа олон улсын сэтгүүл зүйн зорилго, үүрэг, зарчим дэлхий нийтийн жишигтэй адил боловч гадаад ертөнцөөс олон арван жил хаалттай байснаас улбаатай зарим онцлог байхыг үгүйсгэхгүй.

Юуны өмнө нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэх, улс түмэнтэй хамтран ажиллах нээлттэй сэтгэл зүйг бэлтгэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлэг тэргүүн зэргийн ач холбогдолтой байна. Түүнчлэн үндэсний эрх ашигт нийцүүлэхийн тухайд өөрийнхөө аюулгүй байдлыг хамгаалах оновчтой хувилбарыг урьдчилан харж, сэрэмжлүүлэх чиглэлийг түлхүү анхаарах шаардлагатай юм. 1994 онд батлагдсан Монгол улсын үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалын тухай баримт бичгүүд нь олон

улсын мэдээлэлд мөрдөх үндсэн баримжаа болох учиртай. Нийгмийн сэтгэл зүй хөгжил дэвшил өөд тэмүүлж хүн ардын хэлний боловсрол харьцангуй дээшилсэн нь үйл явдлын тухай орчуулга, Монголд үл хамаарах зүйлийн талаарх яриа, тайлбар төдий зүйлээр олон улсын сэтгүүл зүйг орлуулах бололцоогүй болгож байна. Иймээс дэлхий дахины аль ч үйл явдлыг мэдээлэхэд монгол өнцгийг олж харах мэдлэг, мэдрэмж чухал юм.

Олон улсын амьдралын үйл явдлыг мэдээлэхдээ өөрт хамаатай байж болох талыг нь хамт харж бичих эрмэлзэл сүүлийн үед өсч байгаа нь сайшаалтай. Гэвч манай мэргэжлийн сэтгүүлчид асуудалд ийнхүү олон талаас нь хандаж, даацтай үндэслэл, тайлбар хийж бичих талаар дипломатч, судлаач, улс төрчдөөс хоцронгүй явж иржээ. Б.Дүгэр, Д.Бзарваань, Ц.Даваажав нарын зэрэг тоймчдын халаа төдийлөн сайн бэлтгэгдэхгүй байна. Өнөөдөр Д.Баярхүү, С.Баяр, Ж.Бор, Б.Баабар нарын цөөн улс төрч, судлаачаас өөр олон улсын сэдвээр даацтай бичдэг хүн ховор байна. Гэтэл тэдний бичсэн зүйл гол төлөв онолын шинжтэй, том хэмжээтэй учраас олон нийтэд хүртээмжгүй байдаг. Зүй нь тэдний бичиж байгаа шиг даацтай тайлбарыг олон нийтэд ойлгомжтой үг хэл, зохистой арга хэлбэрээр шуурхай мэдээлэхэд л сэтгүүлчийн зорилго орших учиртай.

Нийгмийн хуучин тогтолцооны үед олон улсын сэтгүүл зүйн тусгах объект хязгаарлагдмал байсан тухай дээр өгүүлсэн. Ерээд онд гадаад мэдээлэлд тавих хориг саад арилсан боловч тийм мэдээллийг хүлээн авах нийгмийн сэтгэл зүй бүрдээгүй байв. Дотоод дахь

хямрал, тулгамдсан асуудалд хэвлэл, мэдээллийн анхаарал төвлөрч байлаа. Уншигч, үзэгчдийн мэдээллийн эрэлт хэрэгцээ ч өмсөж, идэхээс хэтэрч чадахгүй байв. Үүний нэг баримт нь 1996 оны 4 дүгээр сараас анхныхаа дугаарыг гаргаж, манай улсын гадаад харилцаа, дэлхий дахины мэдээллийг чухам л монгол сэтгэлгээний үүднээс тусгасан мэдээ, тайлбар нийтэлж байсан «Дэлхийн мэдээ» сонин уншигчгүйн улмаас жил хүрэхгүй хугацаанд гараад хаагдсан явдал юм. Нийгмийн хямрал, бэрхшээлтэй үед «Дэлхийн мэдээ» гэдэг үг «тансаг хэрэглээ» гэсэнтэй адил хол хөндий сонсогддог байлаа.

Нийгэм тогтворжих тутам хүмүүсийн гадаад мэдээлэл сонирхох хэмжээ нэмэгдэж, сонин хэвлэлүүд ч энэ сэдэвт ахиухан анхаардаг болж байна. Үүнтэй зэрэгцэн монгол хүнд зориулсан гадаад мэдээллийн үр нөлөөний шалгуурыг зөв тогтоож, хүлээн авагчдын эрэлт хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэх бодлогыг ч анхаарах болсон байна. Өнөөдөр манай хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд гадаад мэдээллийн сонголтод газар нутгийн хамаарал, сэдвийн ач холбогдол, Монголтой хэрхэн холбогдох зэргийг эн тэргүүнд анхаарахын хамт, олон улсын үйл явдалд сэтгүүлчийн оролцоог нэмэгдүүлж, илэрхийлэх арга хэлбэрийг зөв сонгохыг чухалчилдаг болжээ. Олон улсын амьдралын мэдээлэл аль ч үед ахуй амьдралын сэдвээс илүү эрэлттэй байсангүй. Энэ нь олон улсын сэдвийг бичих арга барилыг сайжруулж, өөрөөр хэлбэл хүлээн авагчдын ашиг сонирхолтой холбож тавихыг шаардаж байгаа юм. Нөгөө талаар олон улсын мэдээлэл

тохиолдлын шинжтэй биш, тухайн үйл явдлын үүсэл, шалтгааныг нээж, өнгөрснийг сануулан, түүхэн хэлхээ холбоонд нь авч үзсэн цогцолбор шинжтэй байх шаардлагыг ч анхаарч үзүүштэй санагддаг.

Өнөөгийн олон улсын мэдээллийн дүр төрхийг өдөр тутмын сонинуудын гадаад мэдээний нүүр, булан, Үндэсний телевизийн «Цагийн хурд» хөтөлбөрийн «Дэлхийн мэдээ»-ний хэсэг, Монголын радиогийн 17 цагийн мэдээ, «UBS», «25 суваг», «Бүргэд», «ТҮ 5» телевизийн гадаад мэдээ тодорхойлж байна. Эдгээр нөлөө бүхий хэрэгслүүд эхлээд өөрийн оронд болж байгаа олон улсын үйл явдлыг, дараа нь хөрш орнуудын дотоод, гадаад бодлого, улмаар Монголд хандивлагч орнуудын гадаад хамтын ажиллагаа, байр суурь, эцэст нь бусад орны мэдээ гэсэн дарааллаар гадаад мэдээллийн ач холбогдлыг тодорхойлдог болжээ. Энэ дарааллыг заримдаа дэлхий дахины халуун цэг, гол үйл явдлууд өөрчилдөг байна.

Олон улсын мэдээлэлд сэдвийн нөлөөлөх чадварыг харгалзах нь зүйн хэрэг юм. Манай хүлээн авагчдын хувьд хамгийн чухал сэдэв нь өөрт хамаатай дотно сэдэв буюу Орос, Хятадын улс төр, эдийн засгийн амьдрал, гадаад бодлого байдаг. Дараа нь байнга сонирхдог хэрэгцээт сэдвүүд буюу осол гамшиг, өвчин тахал, дайн түрэмгийлэл, алан хядах үйл ажиллагаа, экологийн сүйрэл, эдийн засаг ордог байна. Амьдарч байгаа орчин болох дэлхий ертөнцөө ойлгож байх шаардлагаар даяаршлын үйл явц ч чухал сэдвийн тоонд орох болсныг анхаарахгүй байж болохгүй. Үүнтэй холбогдуулан олон улсын

мэдээлэл түгээж ирсэн дадал хэвшлийг ч өөрчлөх шаардлага гарч байна. Мэдээллийн олонх хэрэгсэлд айлчлал зочлол, гэрээ хэлэлцээр, элчин төлөөлөгч солилцсон, цахилгаан утас илгээсэн тухай ёслолын шинжтэй мэдээлэл зонхилсон хэвээр байна. Сонирхлын ямар ч хөшүүрэггүй албаны хуурай мэдээлэл ихэссэнээр олон улсын мэдээлэл хэрэглэгчдээс хол хөндий, ёс төдий зүйл болж, үр нөлөө нь буурах сөрөг нөлөөтэй юм.

Өөрт хамаатай дотно сэдвийн дотор гадаад орнуудаас үзүүлж байгаа зээл, тусламж, бэлэг, хандив, түүнчлэн элдэв салбарын төсөл, сургалт, семинар чухал суурь эзэлж ирэв. Ийм сэдвээр мэдээлэхдээ дан ганц «гардуулав», «бэлэглэв» гэсэн талархлын өнгө аясаар хандаж уншигч, сонсогчдын алга тосох сэтгэлгээг өөгшүүлэх нь цөөнгүй үзэгддэг. Хамтарсан үйлдвэр, үйлчилгээ зэрэг эдийн засгийн мэдээлэлд ч гэсэн мөн л «үүдээ нээсэн», «тууз хайчилсан» тухай ёслолын арга хэмжээг мэдээлэхээс төдий л хэтрэхгүй байна. Зүй нь дээрх арга хэмжээнүүдийн улс төр, эдийн засгийн агуулга, үр нөлөө, эерэг сөрөг талыг жигд харж, зохих шинжилгээ дүгнэлт хийж бичвэл илүү өгөөжтэй болох билээ. Сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалтын үр ашиг, ашигт малтмалын орд ашиглалт, хайгуул шинжилгээ, түүнээс байгаль экологид учирч байгаа сөрөг үзэгдлийг эсэргүүцсэн олон нийтийн хөдөлгөөн өрнөж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дуу хоолойгоо илэрхийлж байгаа нь дэвшилттэй зүйл мөн.

Өөрт хамаатай дотно сэдвийг тусгах тухайд олон нийтийн сэтгэл зүйг харгалзан үзэх нь чухал юм. НҮБ-ын

зэвсгийн шинжээчид Иракаас цөмийн зэвсэг хайж, улмаар холбоотнуудынхаа хамт цэргийн хүч хэрэглэсэн, Израйль Палестины хямрал хурцадсан тухай мэдээллийг хүлээн авагчид зөвхөн сонирхоод өнгөрдөг бол ОХУ-д бензиний үнэ нэмэгдсэн, Хятад улс хилийн боомтоо хаасан тухай мэдээлэл амьдралын хэрэгцээнд шууд холбогддог ороо илүү чухал байдаг. Сүүлийн үед манай телевизийн сэтгүүлчид гадаад орнуудад биеэр очиж монголчуудад хамаатай асуудлыг газар дээрээс нь шууд харуулах болсон нь үр нөлөөгөө өгч байна. Үүнд «Америк дахь монголчууд», «Солонгост ажилладаг монголчууд»-ын тухай цуврал болон «Аялалын цаг», «Үүргэвчтэй аялал» нэвтрүүлгийн зарим хөтөлбөрийг жишээлж болно.

Дэлхийн улс төр, эдийн засгийн амьдралд онцын нөлөөгүй манай орны хувьд олон улсын мэдээлэл орчноо баримжаалах, эрх ашигтай холбогдох гэсэн хоёр хэмжүүрийг гол болгох нь илүү үр нөлөөтэй юм. Гэвч энэ харьцаа ихээхэн алдагдаж чухал мэдээлэл зохих байраа эзлэхгүй байгаа нь мэдээллийн америк сонголт буюу эх сурвалжийн нөлөө, шуугиан хүчирхийллийг сонирхдог шар хэвлэлийн сонголт хоёртой холбоотой байна.

Олон улсын сэтгүүл зүйд сэтгүүлч үйл явдалд оролцож, түүний гэрч болж байхын ач холбогдол их юм. «Монгол

сэтгүүлчид хүний хар нүдээр харснаас өөрийн шар нүдээр үзсэн нь дээр» хэмээн хэлэлцдэг. Америкчууд «Ээж чинь чамд хайртай гэж хэлсэн ч өөр баримтаар заавал шалга» гэгцгээдэг. Аль аль нь нүдээр үзсэн бодитой мэдээллийг эрхэмлэсэн санаа юм. Гадаадад байнгын сурвалжлагч бараг байдаггүй, тусгай сурвалжлагч илгээгээд байх хөрөнгө мөнгөний бололцоогүй зэргээс шалтгаалж сэтгүүлчийн

амьд сурвалжлага, тайлбар үгүйлэгдсээр байна. Ялангуяа ОХУ, БНХАУ-д орон тооны байнгын сурвалжлагч суулгаж, тэдгээрийн дотоод амьдрал, эдийн засгийн хөгжил, түүнээс Монголд үзүүлж болох зэрэг сөрөг нөлөө зэргийг тасралтгүй мэдээлж байх шаардлага өссөөр байгаа юм. Хөрш

«

**Олон улсын сэтгүүл зүйд
сэтгүүлч үйл явдалд оролцож,
түүний гэрч болж байхын ач
холбогдол их юм. «Монгол
сэтгүүлчид хүний хар нүдээр
харснаас өөрийн шар нүдээр
үзсэн нь дээр» хэмээн хэлэлцдэг.
Америкчууд «Ээж чинь чамд
хайртай гэж хэлсэн ч өөр
баримтаар заавал шалга»
гэгцгээдэг.**

»

орнуудын тухай мэдээллийг хөндлөнгийн эх сурвалжаас авснаар хангалтгүй, өрөөсгөл мэдээлэл түгээхэд хүрдэг явдал ч бий. Тухайлбал: ОХУ-д болж байгаа үйл явдлыг барууны эх сурвалжийн тайлбараар авахад дээрээс харж, үл тоомсорлосон, заримдаа хөндий хүйтэн хандсан байдал ч ажиглагддаг. Ийм мэдээлэл монголчуудын уламжлалт сэтгэлгээнд буухгүйн зэрэгцээ хоёрдмол санаа төрүүлж ч болох юм. Бусад орнуудын хувьд өөрт хамааралтай сонирхолтой байх шаардлагыг шалгуур болгон, голч байр сууринаас хандаж, хэрэг явдлын учир шалтгаан, уялдаа холбоог нарийн гаргасан мэдээ,

тайлбар илүү оновчтой байх болно. Түүнчлэн гадаадын агентлаг, эх сурвалжуудын мэдээг харьцуулах, нэгтгэн дүгнэх замаар үйл явдлын бодит дүр зургийг гаргах боломж ч бий.

Манай олон улсын сэтгүүл зүйн практикт гадаадын мэдээллийг түгээхэд улс орныхоо хөгжлийн төвшинтэй уялдсан үндэсний үнэлэмжийг харгалзан үзсэн байдал ажиглагддаг. Жишээлбэл дотоодод болж буй олон улсын мэдээлэлд албан ёсны арга хэмжээ, хандив тусламж, Оросын тухай мэдээлэлд хамтын ажиллагаа, Америкийн хувьд Холливудын оддын амьдрал, дэлхийн үйл явцад оролцсон байдал зэрэгт голчлон төвлөрдөг байна. Харин Японыг Монголд хэрхэн тусалж байгаагаар нь, бусад орнуудын тухайд ихэвчлэн дотоодод нь болсон онцлог явдлаар сонголт хийж мэдээлдэг байна. Гадаад мэдээллийн илүү үр өгөөжтэй, оновчтой байх хувилбар үүнээс өөрөөр байх ч бололцоо бий. Тухайлбал Монголд хамаатай үйл явдлын тухайд үр дүн, хэтийн төлөвийг онцолж, Орос, Хятадын хувьд гол төлөв дотоод амьдралыг нь сэтгүүлчийн оролцоотойгоор тасралтгүй тусгах чиглэлийг барьж болно. АНУ, Японы гадаад бодлого, хамтын ажиллагаанд сэтгүүлчийн тойм, тайлбарыг өргөн ашиглаж, дэлхийн бусад мэдээлэлд эх сурвалжийг түшиглэх хувилбар оновчтой байж болох юм.

Манай хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд гарч байгаа олон улсын мэдээллийг тоон утгаар нь авч үзвэл хангалттай мэт дүн харагддаг боловч үр нөлөөний хувьд анхаарч үзүүштэй асуудал бий. Гадаад мэдээлэл заавал байх ёстой гэсэн хэвшмэл бодлогын үүднээс биш, хүлээн авагчийн хэрэгцээ

сонирхлыг илүү харгалзаж, зөв сонголт хийхийг чухалчлах цаг болжээ.

Даяаршлын үйл явц эрчимжиж байгаа өнөөгийн нөхцөлд аль ч улс орны амьдрал дэлхий ертөнцөөс улам бүр хамааралтай болж байгаа нь олон улсын сэтгүүл зүйг мэдээллийн хэрэгслийн чухал чиглэл болгохыг шаардаж байна. Гэхдээ дэлхийн амьдралд оролцох хэр хэмжээгээ зөв үнэлж түүндээ тохирсон оновчтой хувилбарыг олж тогтоох нь манай олон улсын сэтгүүл зүйн тулгамдсан зорилт мөн. Өнгөрсөн жилүүдэд олон улсын банк, санхүүгийн болон засгийн газрын бус байгууллагуудын дэмжлэгийг хүлээх, хүн төрөлхтний эрх ашигт нийцсэн санал, санаачилга гаргах замаар олон улсын нэр хүндээ өсгөх, хоёр хөрш, хандивлагч орнууддаа дотно хандах зэрэг асуудал манай олон улсын сэтгүүл зүйн гол сэдэв болж ирсэн нь цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан бодлого байв.

Сүүлийн жилүүдэд олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож, Ирак, Афганистан зэрэг оронд цэргийн хүчээ илгээсний дээр дэлхий, бүс нутгийн маргаантай асуудлаар байр сууриа тодорхой илэрхийлж, бие даасан бодлого явуулах болсноор Америк хэмээх хүчирхэг улсыг гурав дахь хөршөө болгож, мянганы сорилтын сангаас тусламж авах эрх авсан нь манай гадаад бодлогын үр дүн, хэвлэл мэдээллийн чухал сэдэв болж байна.

Түүнчлэн Монгол улсын геополитикийн чухал асуудлууд, тухайлбал газрын тос, байгалийн хий дамжуулах хоолой өнгөрөх дамжлага, Ази, Европыг холбосон зам харилцааны нутаг, Оросын хүч чадлын ундарга

гэгдэх Сибирийн үүд хаалга болдог зэрэг аятай боломжийг ашиглах гэсэн идэвхтэй бодлогыг хөхүүлэн дэмжих явдал манай гадаад мэдээллийн бас нэг чухал сэдэв болж ирлээ. Цаашид олон улс, бүс нутагт эзлэх нөлөөнийхөө хүрээг тэлэхэд чиглэсэн ухаалаг гадаад бодлого явуулахад нь улс орондоо туслах, энэ зүгт хандсан олон нийтийн санаа бодолд нөлөөлөх зэрэг нь олон улсын сэтгүүл зүйн үндсэн зорилгын чухал хэсэг байх учиртай. Өнөөдөр харилцан ойлголцох, хамтран ажиллах явдал олон улсын харилцааны шинэ дэг журам болж байгаа хэдий ч дэлхий дахинд нөлөөнийхөө хүрээг тогтоож, түүхий эдийн нөөц, зах зээлийн баазаа өргөжүүлэх том гүрнүүдийн сонирхол байсаар байгаа нь нууц биш. Иймд эдийн засаг, газар нутаг гэсэн хоёр хүчин зүйлийг гадаад сурталчилгаанд гол шалгуур болгож үзэх нь чухал юм. Олон улсын харилцаанд геополитикийн шинжтэй бодлого, тактик боловсруулж байдаг нийгмийн хийгээд улс төрийн шинжлэх ухааны ололтыг өргөн ашиглаж, хүн амынхаа боловсрол, соёлын төвшинд тохирсон гадаад мэдээллийг сонгох явдал ч хэрэгтэй болно. Сүүлийн жилүүдэд дэлхийн геополитикийн хүчний тэнцвэрт харьцаанд хүчтэй нөлөөлж байгаа шашин, соёлын нөлөө, улс төрийн дэглэм, удирдагчдын эрх мэдэл, сэтгэлгээний төвшин, хууль тогтоомжийг хүндэтгэн сахих хэр хэмжээ зэрэг нь олон улсын мэдээлэлд зайлшгүй харгалзан үзэх зүйл болж байна.

Шинжлэх ухаан, техник амьдралд гүнзгий нэвтэрснээр газар зүйн салангид элементүүд болох томоохон нутаг дэвсгэр, далай тэнгис, гол мөрөн, ой тайга мэтийн үүрэг буурах хандлагатай

болов. Түүнчлэн төмөр зам, усан замын харилцааны төрөл хумигдаж дамжуулах хоолой, авто тээвэр, агаарын харилцаа хэлбэрэлтгүй өргөжиж байна. Шинжлэх ухаан, техник технологи, санхүүгийн өндөр чадавхитай жижиг улс орнуудын нөлөө ихсэж байна. Олон улсын мэдээлэлд энэ бүхнийг харгалзан үзэхийг буй болсон нөхцөл байдал шаардаж байгаа юм. Товчоор хэлбэл дэлхий ертөнцийг соргог мэдэрч, амьдрах таатай нөхцлөө бүрдүүлэхэд чиглэсэн гадаад мэдээллийг эрхэмлэх цаг ирсэн байна.

Түүнчлэн өөрийн орны газар зүйн байршил, эдийн засгийн үндсэн чиглэл, соёл, зан заншлын онцлогт тохирсон хил хязгаар, тогтсон орон зай, хүн ам, аж төрөх арга, төрт ёс зэрэг нь харьцангуй тогтвортой байдаг хуурай газрын соёл иргэншилтэй орон гэдэг үүднээс гадаад мэдээллийнхээ сонголтыг хийх учиртай юм. Гэвч хөгжлийн явцад хөлөг онгоцны бүтэц сайжирсан, зэвсэг техник, нийгмийн хөдөлмөрийн хуваарь худалдааны эргэлт нэмэгдсэн зэргээс шалтгаалан далайн соёл иргэншлийн үүрэг эрс нэмэгдсэнийг харгалзан хуурай газрын болон далайн эрч хүчийг хослон ашиглах гадаад бодлогыг сурталчлах хэрэгцээ ч нэмэгдэж байна.

Эцэст нь сэтгүүлчдийн олон улсын харилцааны мэдлэг, гадаад хэлний боловсролыг ахиулах явдал олон улсын мэдээллийн үр нөлөөг сайжруулах чухал хүчин зүйл гэдгийг мартаж болохгүй. Үүнд дээд боловсролын байгууллага чухал үүрэгтэй. Сүүлийн жилүүдэд их сургууль, коллежийн бие даасан байдлыг урамшуулах бодлого явуулсны үр дүнд сургуулиуд мэргэжлийн нарийссан шинэ чиглэлээр

боловсон хүчин бэлтгэх хэмжээ нэмэгдэв. Үүний нэг нь олон улсын сэтгүүл зүйн сургалт юм. Өнөөдөр улсын болон хувийн хэд хэдэн сургууль дотооддоо олон улсын сэтгүүлч бэлтгэхээр туршиж байгаагийн дотор МУИС-д 2002 оноос эхлэн олон улсын сэтгүүлчийн анги нээж, сэтгүүл зүйн үндсэн мэргэжлээс гадна дипломатын онол түүх, олон улсын эдийн засаг, эрх зүй, мэдээлийн харилцаа, дипломат бичиг баримт боловсруулах арга зүй зэрэг нэмэлт хичээл оруулж, суралцагчдын гадаад хэлний мэдлэгт түлхүү анхаарсан шинэ сургалт явуулж эхэлжээ. Түүнчлэн манай сэтгүүлчдээс сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудад магистр, докторын зэрэг хамгаалах, урт богино хугацааны сургалт, семинарт хамрагдах хэмжээ өсч байгаа нь олон улсын сэтгүүл зүйг авч явах орчин цагийн боловсролтой залуу халаа бэлтгэгдэж эхэлснийг харуулж байна.

Ишлэл

- ¹ «Шинэ толь хэмээх бичиг» 1914. №17-20.
- ² Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 85 дахь тал.
- ³ «Монголын үнэн» сонин. 1921. №5.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлэг Г. 1971. Монголын хэвлэл. II боть. УБ.

2. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
3. 1974. Проблемы журналистики. Выпуск 4. Л.
4. Прохоров Е. П. 1998. Введение в теорию журналистики. М.
5. Рэндалл Д. 1996. Универсальный журналист. Алматы.
6. Чулуунбаатар Г. 1999. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. УБ.
7. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. III боть. УБ.

Resume

Here, in this article, we have tried to present the historical traditions of reflecting the international life style in the regular publication of Mongolia as well as the urgent issues currently faced by the periodicals of Mongolia. So, we are recommending the tendency and principles, the geo-political and geo-strategic methodologies for choosing, collecting and spreading international news/information.

Besides, we have classified the international news into 3 groups: the self-relevant close themes, the themes of regular need or interest, and the themes of World cognition. Thus, we have tried to avoid the official non-interesting "dry" information through determining the methodology for increasing the effectiveness of above news.